



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 462

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.10, 5.1 дэх заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2023 оны А/207 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон, нийт 50,380,000.00 (тавин сая гурван зуун наян мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Цагдаагийн ерөнхий газрын Автобаазын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Цагдаагийн ерөнхий газрын дарга, бригадын генерал Т.Сүхболд, Нийслэлийн өмчийн харилцааны газрын дарга В.Оюумаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т уурэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ





Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 1 дугээр сарынны өдрийн
дугаар тогтоолын хавсралт

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН,
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АВТОБААЗЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон он	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Балансын үнэ (төгрөг)
1	Чауган бенбен и стар, 02-91 УКА (цахилгаан автомашин)	2024	Ш	1	50,380,000.00
Нийт дүн					50,380,000.00